



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 18 өдөр

Дугаар A/167

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3 заалт, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 264 дүгээр тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны XII хуралдааны 14, 2022 оны ээлжит XVI хуралдааны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас 2023-2024 оныг “Монголд зочлох жил” болгон зарласантай холбогдуулан “Улаанбаатар травел экспо-2023” олон Улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд Хөвсгөл аймгаа сурталчлан оролцох талбайн түрээс, тохижилт, хэвлэл тараах материал бэлтгэх болон оролцогчдын үйл ажиллагааны зардалд 10,000,000 (арван сая) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардлыг Засаг дарга дансны “Хөвсгөлд зочлох жил” нэрлэсэн жилийн арга хэмжээний зардал”-аас гаргаж зарцуулахыг Төсвийн ерөнхийлөн захирагчийн ерөнхий нягтлан бодогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Батжаргал)-д зөвшөөрсүгэй.

3. 2023 оны 05 дугаар сарын 19-21-ний өдрүүдэд зохион байгуулагдах үзэсгэлэнд өөрийн аймгийн онцлог, байгалийн үзэсгэлэнт газар болон аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлан танилцуулж, аялал жуулчлалын байгууллага, аж ахуй нэгжүүдийг нэгдсэн удирдлагаар ханган, үр дүнтэй оролцож, тайлан мэдээг аймгийн Засаг даргад танилцуулж ажиллахыг аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар (П.Мөнхжаргал)-т үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН

671 0010013